



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (цаашид Комисс гэх)-ын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Комиссын тухай хууль тогтоомж

2.1. Комиссын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бурдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

3 дугаар зүйл. Комисс, түүний үйл ажиллагааны зарчим

3.1. Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага мөн.

3.2. Комисс нь гурван гишүүнээс бурдэнэ.

3.3. Комисс нь үйл ажиллагаанд хууль дээдлэх, хараат бус байх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шударга, ил тод байх зарчмыг баримтална.

3.4. Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн Комисс, түүний гишүүний үйл ажиллагаанд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Комиссын гишүүнийг томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах

4 дүгээр зүйл. Комиссын гишүүнд нэр дэвшигч

4.1. Комиссын гишүүнд нэр дэвшигч нь хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, хүний эрхийн асуудлаар зохих мэдлэг, туршлагатай, ял шийтгэлгүй, Монгол Улсын гучин таван насанд хүрсэн иргэн байна.

5 дугаар зүйл. Комиссын гишүүнд нэр дэвшигчийн томилох

5.1. Комиссын гишүүнд нэр дэвшигчийн нэрийг Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

5.2. Улсын Их Хурал нэр дэвшигчийг Комиссын гишүүнд томилохоос татгалзсан бол Улсын Их Хурлын дарга арван дөрвөн хоногийн дотор энэ хуулийн 5.1-д заасан журмын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

5.3. Нэг хүний нэрийг дахин дэвшүүлж болохгүй.

5.4. Нэр дэвшигчийн нэрийг өргөн мэдүүлснээс хойш гуч хоногийн дотор Улсын Их Хурал уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.5. Комиссын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанаас өмнө хуульд заасан үндэслэлээр албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, огцорсон, нас барсан тохиолдолд Улсын Их Хурал жар хоногийн дотор энэ хуульд заасны дагуу Комиссын гишүүнийг нөхөн томилно.

5.6. Комиссын даргыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Комиссын гишүүдээс Улсын Их Хурал гурван жилийн хугацаагаар томилно.

5.7. Комиссын гишүүн сургалт, эрдэм шинжилгээний ажил хийхээс бусад энэ хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв гишүүн томилогдооосоо өмнө өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүрэгт ажлаасаа чөлөөлөгднө.

6 дугаар зүйл. Комиссын гишүүний бүрэн эрхийн хугацаа

6.1. Комиссын гишүүний нэгэн бүрэн эрхийн хугацаа зургаан жил байна.

6.2. Комиссын гишүүний бүрэн эрх Монгол Улсын Үндсэн хуульд тангараг өргөснөөр эхэлж, Комиссын шинээр томилогдсон гишүүн тангараг өргөснөөр дуусгавар болно.

6.3. Комиссын гишүүнийг нэг удаа улируулан томилж болно.

7 дугаар зүйл. Комиссын гишүүн тангараг өргөх

7.1. Комиссын гишүүн томилогдооосоо хойш гуч хоногийн дотор “Би Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Монгол Улсын хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хамгаалах үргээ чин шударгаар биелүүлэхээ батлан тангараглая.“ хэмээн Монгол Улсын Үндсэн хуульд тангараг өргөнө.

7.2. Комиссын гишүүний тангараг өргөх ёслолын журмыг Улсын Их Хурлын дарга тогтооно.

8 дугаар зүйл. Комиссын гишүүнийг чөлөөлөх, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцуулах

8.1. Дараахь тохиолдолд Улсын Их Хурал Комиссын гишүүнийг албан тушаалаас нь чөлөөлнө:

8.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүнд нэрээ дэвшүүлсэн;

8.1.2. бусад албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон;

8.1.3. биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос өөрөө хүсэлт гаргасан.

8.2. Комиссын гишүүн гэмт хэрэгт холбогдсон, түүнчлэн энэ хуулийн 23.1-д заасны дагуу баривчлагдсан бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг энэ тухай эрх бүхий байгууллагын гаргасан санал, шийдвэрийг хүлээн авснаас хойш арван дөрвөн хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэнэ.

8.3. Комиссын гишүүн гэмт хэрэгт холбогдолгүй, гэм буруугүй болохыг тогтоосон эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэн түүний бүрэн эрхийг сэргээж Улсын Их Хурал тогтоол гаргана.

8.4. Комиссын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсноор түүнийг албан тушаалаас нь огцууулж Улсын Их Хурал тогтоол гаргана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Комисст гомдол гаргах

9 дүгээр зүйл. Гомдол гаргах эрх

9.1. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч энэ хуульд заасны дагуу Комисст гомдол гаргах эрхтэй.

9.2. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний адил Комисст гомдол гаргах эрх эдэлнэ.

9.3. Иргэний эрхийн бүрэн чадамжгүй, зарим буюу хэсэгчилсэн чадамжтай хүнийг түүний хууль ёсны төлөөлөгч-эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь, түүнчлэн сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүнийг хуульд заасан төлөөлөгч нь төлөөлж гомдол гаргаж болно.

9.4. Төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллага энэ хуулийн 9.1-д заасан эрхийг мөн адил эдлэх бөгөөд төлөөлөгчөөрөө дамжуулан гомдол гаргана.

9.5. Энэ хуулийн 9.3, 9.4-т заасан төлөөлөгч нь өөрийн бүрэн эрхийг нотолсон баримт бичигтэй байна.

10 дугаар зүйл. Гомдол гаргах хэлбэр

10.1. Гомдлыг монгол хэлээр бичгээр, эсхүл амаар биечлэн гаргана. Монгол хэл мэдэхгүй хүн эх хэлээрээ гомдол гаргаж болох бөгөөд гомдлоо монгол хэлнээ орчуулж, зохих журмаар баталгаажуулсан байна.

11 дүгээр зүйл. Гомдолд тавих шаардлага

11.1. Гомдолд дараах зүйлийг тусгасан байна:

11.1.1. гомдол гаргагч гомдлоо захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх;

11.1.2. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан ямар эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн болохыг заах;

11.1.3. гомдол гаргагч өөрийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурсан байх;

11.1.4. гомдолд холбогдож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар холбогдох бусад баримтыг хавсаргасан байх.

11.2. Комиссын гишүүн нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэрэг, маргааны талаархи гомдлыг хүлээн авахгүй.

12 дугаар зүйл. Гомдол хүлээн авах, хариу өгөх хугацаа

12.1. Гомдол гаргагч эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн өдрөөс, эсхүл тийнхүү зөрчигдсөн гэдгийг мэдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор гомдол гаргана.

12.2. Комисс нэр, хаяггүй гомдол хүлээн авахгүй.

12.3. Комисс гомдлыг хүлээн авснаас хойш гуч хоногт багтаан хариуг өгөх бөгөөд нэмэлт судалгаа, шалгалт хийх шаардлагатай бол уул хугацааг Комиссын дарга жар хүртэл хоногоор сунгаж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Комисс, түүний гишүүний бүрэн эрх

13 дугаар зүйл. Комиссын бүрэн эрх

13.1. Комисс нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах;

13.1.2. хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах;

13.1.3. олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх;

13.2. Комисс нь бүрэн эрхийнхээ хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

13.2.1. хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах;

13.2.2. олон улсын, бүсийн, хүний эрхийн бусад үндэсний байгууллагатай хамтран ажиллах;

13.2.3. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бичих;

13.2.4. хүний эрхийн талаархи хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах;

13.2.5. хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих;

13.2.6. олон улсын хүний эрхийн гэрээг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орохыг дэмжих.

14 дугаар зүйл. Комиссын даргын эрх, үүрэг

14.1. Комиссын дарга нь дараахь эрх, үүрэгтэй:

- 14.1.1. Комиссыг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;
- 14.1.2. Комиссын ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх;
- 14.1.3. Комиссын дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх.

15 дугаар зүйл. Комиссын гишүүний гомдол хүлээн авахтай

холбогдсон бүрэн эрх

15.1. Комиссын гишүүн гомдол хүлээн авахтай холбогдсон дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 15.1.1. гомдлыг хүлээн авч, хянан үзэх;
- 15.1.2. энэ хуулийн 11 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй гомдлыг хүлээн авахаас татгалзах;
- 15.1.3. эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааны талаархи гомдлыг харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;
- 15.1.4. гомдол гаргагчид зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаар ямар эрх, үүрэгтэй болохыг тайлбарлах.

16 дугаар зүйл. Комиссын гишүүний гомдлын мөрөөр шалгалт

хийхтэй холбогдсон бүрэн эрх

16.1. Комиссын гишүүн гомдлын мөрөөр шалгалт хийх явцад дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1. гомдол гаргагч, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүнээс гомдлын талаар бичгээр тайлбар авах. Хэрвээ гомдол гаргагч нь бичиг үсэг мэдэхгүй бол амаар тайлбар авч, энэ тухай тэмдэглэл хөтөлсөн байна;

16.1.2. гомдол гаргагч, холбогдох хүмүүсийг дуудан ирүүлэх;

16.1.3. гомдолтой холбогдолтой асуудлаар аль ч аж ахуйн нэгж, байгууллагад саадгүй нэвтрэн орж, түүний хурал, зөвлөлгөөнд оролцох, холбогдох албан тушаалтантай биечлэн уулзах;

16.1.4. шаардлагатай нотлох баримт, албан бичиг, мэдээллийг байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах, газар дээр нь танилцах;

16.1.5. тусгай мэдлэг шаардагдсан тохиолдолд зохих байгууллагын шинжээчийг томилж, дүгнэлт гаргуулах;

16.1.6. гомдлыг хянан үзэх явцад уул гомдол нь эрүү, иргэний хэрэг маргааны шинжтэй гэж үзвэл түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтанд харьяаллын дагуу шилжүүлэх;

16.1.7. аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд дангаар буюу төрийн эрх бүхий байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд санал болгосны үндсэн дээр хамтран шалгалт явуулах;

16.1.8. бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзсэн тохиолдолд холбогдох хуульд заасан журмын дагуу төр, байгууллага, хувь хүний нууцтай танилцах.

16.2. Комиссын гишүүн албан үүргээ гүйцэтгэх явцад түүнд илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг чандлан хадгална.

17 дугаар зүйл. Комиссын гишүүний гомдлыг шийдвэрлэхтэй

холбогдсон бүрэн эрх

17.1. Комиссын гишүүн гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1. аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд хуулиар тогтоосон журмын дагуу биечлэн болон төлөөлөгчөө оролцуулах;

17.1.2. хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн албан тушаалтанд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулах тухай хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;

/Энэ хэсэгт 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

17.1.3. хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн үйл ажиллагаагаа зогсоохыг байгууллага, албан тушаалтнаас шаардах;

- 17.1.4. талуудыг эвлэрүүлэх замаар асуудлыг шийдвэрлэх;
- 17.1.5. гомдол үндэслэлгүй гэж үзвэл гомдол гаргагчид буцаах.
- 17.2. Энэ хуулийн 17.1.1-д заасны дагуу гаргасан нэхэмжлэл шүүхийн зардлаас чөлөөлөгднө.
- 17.3. Комиссын гишүүн гомдлыг хянан үзсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаар гомдол гаргагчид мэдэгдэх үүрэгтэй.

18 дугаар зүйл. Комиссын гишүүний хүний эрх , эрх чөлөөг

хангах талаархи бусад бүрэн эрх

- 18.1. Комиссын гишүүн нь Улсын Их Хурлын чуулган, Засгийн газрын хуралдаанаар хүний эрхтэй холбогдсон асуудал хэлэлцэхэд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын хүсэлтээр зөвлөх эрхтэй оролцож болно.
- 18.2. Комиссын гишүүн нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа талаархи мэдээллийг үндэслэн өөрийн санаачлагаар, эсхүл аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүсэлтээр шалгалт хийж болно.
- 18.3. Комиссын гишүүн нь хүний эрхийн асуудлаар судалгаа хийх зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгосон, шуухээр шийдвэрлэгдсэн эруү, иргэний хэргийн материалтай танилцаж болно.
- 18.4. Комиссын гишүүн нь хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай санаалаа хууль санаачлах эрх бүхий албан тушаалтан, байгууллагад уламжилна.
- 18.5. Комиссын гишүүн нь хүний эрхийн асуудлаар төрийн байгууллагын хүсэлтээр зөвлөгөө өгнө.
- 18.6. Энэ хуулийн 3.2-т заасан гишүүдээс нэг нь жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг хариуцна.

[/Энэ хэсгийг 2011 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

19 дүгээр зүйл..Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж

- 19.1. Комиссын гишүүн нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлага, зөвлөмж гаргана.
- 19.2. Комиссын гишүүн нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл тухайн хүний эрх, эрх чөлөөг сэргээж, зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллагад шаардлага бичиж хүргүүлнэ.
- 19.3. Комиссын гишүүн нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй тохиолдолд шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өөрийн эрх хэмжээний хүрээнд зөвлөмж гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.
- 19.4. Комиссын гишүүний шаардлагыг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан долоо хоногийн дотор, зөвлөмжийг хүлээн авсан бол гуч хоногийн дотор авсан арга хэмжээнийхээ тухай бичгээр хариу мэдэгдэнэ.
- 19.5. Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авахаас татгалзсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны талаар хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж болно.
- 19.6. Комиссын гишүүн нь гаргасан шаардлага, зөвлөмжөө хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, мэдээлэх эрхтэй.

20 дугаар зүйл. Комиссын илтгэл

- 20.1. Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд илтгэнэ.

[20.2. Комиссын илтгэлийг "Төрийн мэдээлэл" сэргүүлд нийтлэнэ.](#)

[/Энэ хэсгийг 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

ТАВДУГААР БҮЛЭГ

Комиссын гишүүний бүрэн эрхийн баталгаа

21 дүгээр зүйл. Улс төрийн баталгаа

- 21.1. Комисс, түүний ажлын албанад улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Комиссын гишүүн албан тушаал хаших хугацаандаа улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.

21.2. Комиссын гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

22 дугаар зүйл. Эдийн засаг, нийгмийн баталгаа

22.1. Комиссын гишүүний үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

22.2. Комиссын төсвийг түүний саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж улсын төсөвт тусгайлан тусгах бөгөөд энэхүү төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

22.3. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлдээ тохирсон цалин авна.

/Энэ хэсгийг 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

22.4. Комиссын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу өөр ажил эрхлэх хүртэлх зургаан сарын хугацаанд Комиссын гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс буурахааргүй тэтгэмж, хэрэв бага цалинтай ажил эрхэлж байгаа бол цалингийн зөрүүг мөн хугацаанд олгоно.

23 дугаар зүйл. Хууль зүйн баталгаа

23.1. Комиссын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад хорин дөрвөн цагийн дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд Комиссын гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих болон шүүхийн журмаар Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, гэр, албан өрөө, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

/Энэ хэсэгт 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

23.2. Хуульд зааснаас бусад тохиолдолд Комиссын гишүүнийг ажлаас чөлөөлөх, огцуулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

23.3. Комиссын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

23.4. Комиссын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, иргэд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

24 дүгээр зүйл. Комиссын ажлын зохион байгуулалт

24.1. Комисс нь ажлын албатай байна. Комисс нь ажлын албаны дүрмийг баталж, орон тоо, цалингийн санг Улсын Их Хурлаас баталсан төсөвт багтаан тогтооно.

24.2. Комиссын ажлын албаны ажилтан төрийн захиргааны албан хаагч байна.

24.3. Комисс нь үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий өмгөөлөгчдийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн холбоо, хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөл байгуулж болно.

24.4. Комисс нь шаардлагатай гэж үзсэн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, төрийн бус байгууллагаар судалгаа хийлгэж болно.

25 дугаар зүйл. Комиссын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас

25.1. Комисс тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, төрийн сүлд бүхий хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

26 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

26.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ